



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 445

Улаанбаатар хот

**Э.Ариунбилэгийг ажлаас чөлөөлж,  
албан тушаалд томилох тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 27.1.2 дахь заалт, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйчилгээний албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 91 дүгээр тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/11540 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Энх-Амгалангийн Ариунбилэгийг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Адаацаг сумын улсын бүртгэгчээр томилсугай.

2.Э.Ариунбилэгт 30/1-09 дугаартай улсын бүртгэгчийн тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсүгэй.


3.Э.Ариунбилэгийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг нээхийг Иргэний улсын бүртгэлийн газар /Т.Нармандах/-т даалгасугай.

4.Албаны нууцтай танилцах эрх олгон, төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг танилцуулахыг нууц хамгаалах ажилтан /Ж.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

5.Э.Ариунбилэгийн албан тушаалын цалинг төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-6-2-д хамааруулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 18, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, хоол унааны нөхөх зардлыг холбогдох журмын дагуу тус, тус тооцон олгохыг Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс /Ж.Өлзийжаргал/-т зөвшөөрсүгэй.

6.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571007581